

**Удирдах ажилтнуудын 11 дүгээр сарын 25-ны өдрийн
шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүргийн биелэлт**

2019 оны 12 дугаар сарын 09

| № | Өгөгдсөн үүрэг, даалгавар | Хэрэгжүүлэх хугацаа | Хэрэгжүүлэх байгууллага | Биелэлт | Хэрэгжилтийн хувь |
|---|--|-----------------------------|--|--|-------------------|
| 1 | Аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг 12 дугаар сарын 10-15-ны өдрүүдэд малчидтай уулзаж санал хүсэлтийг сонсох, өвөлжилтийн бэлтгэл бэлэн байдалтай танилцах ажлыг зохион байгуулахаар төлөвлөж байна. Иймд ажлын хэсэгт орох дээрх байгууллагууд өөрийн чиг үүргийн хүрээнд удирдамж, хөтөлбөрт оруулах ажлын саналаа Онцгой байдлын газарт ирүүлэх | 2019.11.29-ний өдрийн дотор | Цагдаагийн хэлтсийн Замын цагдаагийн тасаг, Мэргэжлийн хяналтын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газар, Нэгдсэн эмнэлэг, Ус, цаг уур орчны шинжилгээний төв, Сумдын Засаг дарга нарт | Шивээговь сумын ЗДТГ- Аймгийн онцгой байдлын газарт саналыг 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 01/973 тоот албан бичгээр хүргүүлсэн. Мал эмнэлгийн газар- Аймгийн онцгой байдлын газарт саналыг 2019 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 298 албан тоот албан бичгээр хүргүүлсэн. Ус, цаг уур орчны шинжилгээний төв, Цагдаагийн хэлтэс, Мэргэжлийн хяналтын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Нэгдсэн эмнэлэг, Сүмбэр, Баянтал сумын ЗДТГ саналаа ирүүлсэн талаар тайлагнаж ирүүлээгүй. Онцгой байдлын газар саналыг нэгтгэж ирүүлээгүй. | 30 |
| 2 | Ирэх оны төсөв, төлөвлөгөө боловсруулахдаа Шивээговь сумын цэвэр усны эх үүсвэр, хогийн цэгийг салгах, сумд олон жил болсон хур хогноосоо салах зэрэг ард иргэдээ аятай тухтай амьдрах нөхцөл бололцоог нь бүрдүүлэхэд анхаарч ажиллах | 2019.12.05-ны өдрийн дотор | Шивээговь сумын Засаг дарга | Шивээговь сумын ЗДТГ- Сумын төвийн цэвэрлэх байгууламжийн зураг төсвийг сумын ОНХС-ийн 15,9 сая төгрөгөөр “Гидродизайн инноваци” ХХК-тай гэрээ байгуулан 15 га талбайд хийж гүйцэтгэж байна. Сумын төвлөрсөн хогийн цэгийг нүүлгэн шилжүүлэхээр газрын асуудлыг 2020 оны ГЗБ төлөвлөгөөнд сумын төвөөс баруун урагш байгуулахаар ИТХ-д санал хүргүүлсэн. | 100 |
| 3 | Адууны нийлүүлэг өвчний талаар Уяачдын холбооны зөвлөгөөн дээр мэдээлэл хийх | 2019.11.26-ны өдөр | Мал эмнэлгийн газарт | Уяачдын холбооны зөвлөгөөн дээр мэдээлэл хийгдээгүй байна. | 0 |

| | | | | | |
|---|---|----------------------------|---|---|--------------------------------------|
| 4 | “Хоггүй цэвэрхэн – Монгол” аяны төлөвлөгөөний дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын газраас зохион байгуулж буй ажлуудад идэвхтэй оролцох, байгууллагын орчны цэвэрлэгээ хийх | - | Бүх байгууллагууд | Байгаль орчин аялал жуулчлалын газар-“Хоггүй цэвэрхэн – Монгол” аяны төлөвлөгөөний дагуу холбогдох зохион байгуулалтын арга хэмжээг авч Тохижилт Сүмбэр ОНӨҮГ-тэй 4,0 сая төгрөгийн гэрээ байгуулан ажил гүйцэтгүүлж байна. Сүмбэр сумын ЗДТГ- Аяны хүрээнд багуудын цэвэрлэгээ зохион байгуулах, нийтийн эзэмшлийн талбайг тохижуулахаар төлөвлөж байна. Баянтал сумын ЗДТГ- 12 дугаар сарын 03-ны өдрүүдэд Сүлд овооны орчны хог туурийг цэвэрлэн булж 256 тн элсээр хучиж нөхөн сэргээлтийн ажлыг хийсэн. Шивээговь сумын ЗДТГ- Шинэ оноо хоггүй угтах зорилго тавин ажиллаж 2019 оны 12 дугаар сарын 11-ны өдөр бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулахаар Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 1/970 тоот албан бичгийг байгууллагуудад хүргүүлээд байна. | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй |
| 5 | Төрийн албан хаагчийн хувцаслалтад анхаарах | 2019.12.05-ны өдрийн дотор | Төрийн бүх байгууллагууд | Байгууллагын удирдлагууд хувцаслалтандаа анхаарах талаар үүрэг чиглэл өгсөн. | 100 |
| 6 | Отрын бүсэд гэрээтэй, хуваарьтай малчдыг отроор байлгах ба бусад малчдыг отроор нүүж ирэхийг болиулах, нүүж ирсэн бол аймгийн нутаг дэвсгэрээс гаргах | - | Сумдын Засаг дарга нар, хуулийн байгууллагууд | Баянтал сумын ЗДТГ- Дундговь аймгийн 5 сумаас отроор өвөлжих 7 өрхийн 13890 толгой малыг шүлхий, мялзан өвчнөөс урьдчиланс сэргийлэх вакцинжуулалтанд хамруулсан. Дамжин өнгөрч байгаа 15 өрхийн 17570 толгой малд хяналт тавих ажлыг хэсэг томилогдож 2 удаа хөдөөгүүр явж 22 өрхөд нүүх мэдэгдэл өгсөн. Шивээговь сумын ЗДТГ- Шивээговь сумын нутаг дэвсгэрт Дундговь аймгийн 4 малчин өрх оторлож байгааг 2 дугаар багийн ЗД нүүлгэх албан мэдэгдэл хүргүүлээд байна. Отор нүүдлээр дайран өнгөрч байгаа малчдыг сумын нэвтрүүлж байна. | Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй |
| 7 | Баянтал сум шуурхайн мэдээллээ сайжруулах | - | Баянтал сумын Засаг дарга | Шуурхайн хуралд танилцуулах мэдээллийг чанаржуулж танилцуулах болно. | 100 |
| 8 | Биелэлтийн дундаж хувь | | | | 66,0 |

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС